

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



3
2018

VOL. 150

 **Үүсгэн байгуулагчийн сургаал**

Амьдралд ойрхон сургаал айлдах

Бурханы сургаалыг хэцүү онол маягаар айлдах биш ямар ч хүнд ойлгомжтой байхаар айлдах хамгийн чухал. Ойлгомжтой гэдэг нь ямар ч хүн өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болохоор айлдахыг хэлнэ. Яагаад гэвэл сургаалын гайхамшигийг биеэрээ хэрэгжүүлж байж л ойлгодог.

Хүн өөрөө бодитоор хийж үзсэн зүйлдээ итгэхгүй байна гэж байхүй. Чин сэтгэлээсээ итгэж сүсэглэснээр заавал үр дүн гардаг. Улмаар итгэж биширсэн зүйлээ бусад хүнд дамжуулмаар санагдаж, түүнийг сонссон хүмүүс ч гэсэн ар араасаа сургаалын гайхамшигийг

мэдэрдэг.

Хүмүүсийн хүсэж буй зүйл, сонсохыг хүссэн зүйлийг ярих юм бол хэн хүнгүй бие сэтгэлээрээ шимтэн сонсдог. Мөн бурханы сургаалын ач буяныг бүх хүмүүс хүртэх болтугай гэсэн чин сэтгэлээр сургаал айлдсанаар хүмүүс ар араасаа цугларан ирэх болно.

Харин өөрийнхөө хүссэн зүйлийг л яриад, хүмүүсийн сонсохыг хүссэн зүйлийн талаар ярихгүй бол хичнээн өөрөө хичээлээ гээд хүний сэтгэлийг хөдөлгөж чадахгүй.

Living the Lotus
Vol. 150 (2018.03)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp
Ахлах редактор: Саитоо Кооичироо
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Байгууллагын 80 жилийн ойг угтан:
Ард иргэдтэй хамтдаа
аз жаргалтай болохын төлөө

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бодисадва нар олноор амьдардаг хотыг зорьцгооё

Манай байгууллага олон хүмүүсийн ач буянаар 80 жилийн ойтой золгоод байна. Түүхийн хувьд харьцангуй залуу боловч одоогоос 30 жилийн өмнө Үүсгэн байгуулагч тус сэтгүүлд ийнхүү бичиж байжээ.

“Дэлхийн хүн төрөлхтнийг аврах нь бидний эцсийн зорилго боловч өмнөө байгаа хүнийг аз жаргалтай болгох, өөрийн гэрийг засах, амьдарч байгаа дүүрэг, нийгмийг амар амгалан болгох гэсэн эргэн тойрныхоо асуудлыг хойш нь тавилгүй, нухацтай хандах чухал.” /1988 оны 3-р сарын сэтгүүлээс/

Тэмдэглэлт жилээр дамжуулан шинэ алхмыг эхлэх гэж байгаатай холбогдуулан байгууллагын 50 жилийн ойн энэхүү айлдварын утга учрыг дахин бодож үзлээ.

Өмнө би “нийгмийн ард иргэд аз жаргалтай болсноор гишүүд бид аз жаргалтай болно” гэж хэлж байсан. “Нийгмийг амар амгалан болгох” гэдэг нь тэнд амьдарч байгаа хүн бүр өөрийн аз жаргал төдийгүй нийгмийн тогтвортой байдал, бүх хүмүүсийн аз жаргал гэсэн нийтийн сайн сайханд санаа тавьж, өөрийн амьдралд хамаатай бүх зүйлд анхаарал хандуулж, гэгээлэг гэр бүлийг бий болгохыг хэлнэ. Зовлон бэрхшээлээр дүүрэн бодит нийгэм ийнхүү амар амгалан газар болох юм.

Үүсгэн байгуулагч үргэлж “нийгэмд хандсан үйлийг баяртайгаар хүлээн авч бай” гэж хэлдэг байсан. Амьдарч байгаа дүүрэг, нутаг орныхоо төлөө өөрийгөө зориулж, дэргэд зовж шаналж байгаа хүн байвал сэтгэлийг нь ойлгож, санаа зовох зүйл байна гэх хүн байвал яриаг нь сонсох. Ийм бодисадва шиг хүн олноор амьдрах нийгмийг бий болгох нь хүмүүсийн аз жаргалын төлөө залбирдаг бидний зорилго биш гэж үү? Хэрэв бүрэг царайлж, сэтгэлээр унасан хүнтэй таарвал тэр хүний сэтгэлд гэрэл асааж, инээмсэглэлийг бэлэглэж, нийгмийг бүхэлд нь гэрэлтүүлж явах нь сүсэг бишрэлтэй бидний үүрэг гэж бодож байна.

Гэр бүлийн зөөлөн дулаан уур амьсгалыг нийгэмд түгээцгээе

Өндөр газраас хотын нар жаргах үеийг харуулсан бичлэгийг үзэж байсан юм байна. Нар жаргахтай зэрэгцээд айлаас айл дамжин гэрэл ассаар түнэр харанхуйн ёроолд хот гэр чигээрээ гэрэлтэн тодорч ирдэг. Нийгэмд аз жаргал түгнэ гэдэг магадгүй энэ дүр зурагтай адилхан байх. Цонхоор гэрэл цацарч, жихүүн хүйтэн орой ч гэсэн гэр бүл инээмсэглэл, зөөлөн дулаан уур амьсгалаар дүүрч, ямар ч хүн гэртээ харимаар санагдах тийм халуун дулаан гэр бүл нэг нэгээр нэмэгдэж байна гэж төсөөлж болох юм.

Эдгээр айлуудын хамгийн эхний айл бол та бүхний гэр бүл юм. Гэр бүлээрээ эв найртай, хүндэтгэл, хайраар холбогдож, сэтгэл амар амгалан байх гэр бүл. “Өөрийн гэр бүл”-ийг ийм болгох нь нийгмийг бүхэлд нь аз жаргалтай болгох эхний алхам билээ.

Яагаад гэвэл та бүхний нутаг орон, хөрш айлынхаа төлөө гэсэн сэтгэл жишээлбэл гадаа үүдээ шүүрдэж цэвэрлэх үед ч гэсэн аяндаа хажуу айлын үүдийг ч гэсэн шүүрдчихье гэсэн үйлд хөдлөл болж хувирдаг болохоор юм. Салхилж явахдаа танихгүй хүнтэй таарсан ч гэсэн гэгээлгээр “өглөөний мэнд”, “сайн байна уу” гэж мэндэлдэг болно. Ингэж бага багаар хүмүүсийн хооронд эв найртай харилцаа үүсэж, өөрийн болон бусад хүмүүсийн сэтгэл сайжирснаар нийгмийг гэрэлтүүлэх хамтрагч буюу бодисадва нар бага багаар нэмэгдэнэ гэж бодож байна.

Мөн манай байгууллагын салбар нийгэмлэг дүүрэг болгонд байдаг. Салбар нийгэмлэг нь гишүүн та бүхний хувьд сэтгэлийн амар амгаланг мэдрэх газар байхаас гадна ямар ч хүн бие сэтгэлээ амрааж болох газар байгаасай гэж хүсэж байна.

Үүний тулд бид өөрсдөө манлайлан нийгмийг уриалах хэрэгтэй. “Өгч байж авдаг” гэдэг шиг өөрсдөө нийгэмлэгээсээ гарч явж уриалахгүй бол хүн ирэхгүй. Үүнийг санаж нутаг орныхоо ард иргэдтэй хамт хотоо амар амгалан болгоцгооё. Эхлээд өөрийн гэр бүлийг аз жаргалтай болгож, цаашлаад ард иргэд хоорондоо эв найртай болох нь дэлхий нийтийн энх тайвны төлөөх нэг алхам болох юм.

“Косей” сэтгүүл 3-р сарын дугаараас



The 7 Parables of the Lotus Sutra

Оройн Дээд
Цагаан Лянхуа Судар



Хувилгаан балгасын үлгэр

7-р бүлэг: Хувилгаан
балгасаар зүйрлэхүй

Олон хүмүүс нандин эрдэнэ олж авахаар холын урт бартаат замаар явж байв. Тэр хүмүүс дунд нэгэн удирдагч байв. Тэр удирдагч эрдэм мэдлэг арвин, билиг оюун төгөлдөр бөгөөд замын төгсгөлд юу хүлээж байгааг сайн мэдэж байв.



Холын замд гарсан хүмүүс замдаа ядарч туйлдан удирдагчдаа ийнхүү хэлэв: “Бид ядраад цааш явж чадахгүй боллоо. Ирсэн замаараа буцаад явъя гэж бодож байна.” Удирдагч нь тэднийг өрөвдөн, замын талаас цаахантай уран аргын хүч ашиглан том хувилгаан балгас босгов.

Хүмүүс баярлан тийшээ очиж, цамхаг дотор амарцгаав. Удирдагч хэсэг хугацааны дараа хүмүүсийн ядаргаа бүрэн тайлагдсаныг анзаарч ийнхүү хэлэв: “За цааш явцгаая. Эрдэнэ байгаа газарт удахгүй хүрнэ. Энэ балгас бол та бүхнийг түр амраахын тулд босгосон хиймэл цамхаг юм.” Ингээд эрч хүчтэй болсон хүмүүс эрдэнэ олж авахаар цааш явцгаав.



Тайлбар:

“Урт бартаат зам” гэдэг нь зовлонгоор дүүрэн амьдралыг илэрхийлнэ. Хүмүүс бид жинхэнэ аз жаргал “нандин эрдэнэ (Бурханы билиг оюун)”-ыг олж авахаар амьдралаар аялан явдаг. Биднийг удирдан чиглүүлдэг удирдагч бол Бурхан юм.

Хүмүүс бид санаснаар болохгүй амьдралд аз жаргалтай болохын төлөө бурханы үйлийг хийдэг боловч замдаа ядарч туйлддаг. Яагаад гэвэл амьдралын зовлон ар араасаа гарч ирэн дуусна гэж байддаггүй билээ. Тиймээс бурханы үйл хийхээс залхаж, сэтгэлээр унаж, эргэж буцах сэтгэл төрдөг.

Тийм үед Бурхан замын талаас цаахантай хувилгаан балгас босгосон байна. Хувилгаан балгас гэдэг нь *Хоёр Хөлгөн (ширваган ба нирваан бологсод)* хэмээх уран арга бөгөөд биднийг амьдралын бодит зовлонгоос ангижруулах арга юм. Бидний зорьж буй жинхэнэ аз жаргал (эрдэнэ) гэдэг нь үнэндээ Бурханы билиг оюуныг хэлж байгаа боловч ихэнх хүмүүс түүнийг ойлгохгүй, бодит амьдралын зовлонгоос л ангижихыг хүсэн, “аз жаргалтай л болох юмсан” гэж хүсдэг. Тиймээс Бурхан эхлээд бидэнд “Шүтэн барилдлагын сургаал”-ыг айлддаг. Энэ нь “учирч буй аливаа үзэгдэл үргэлж хувьсан өөрчлөгдөх бөгөөд хиймэл байдаг (өөрөөр хэлбэл олон зүйлд баригдсан сэтгэлээ чөлөөлснөөр сэтгэл амар амгалан болно).” гэсэн сургаал юм. Энэ сургаалыг хэрэгжүүлснээр хувилгаан балгаст амарсан хүмүүс шиг эрх чөлөөтэй, сэтгэл амар амгалан болдог.

Үүнд сэтгэл ханан амарч байтал удирдагч хувилгаан балгасыг алга болгон “жинхэнэ аз жаргалд хүрэх арай болоогүй байна” хэмээн айлдана. Жинхэнэ аз жаргал бол өөрөө ганцаархнаа амар амгалан байх биш, дэлхий ертөнцийг бүхэлд нь аз жаргалтай болгохын төлөө өөрийн хүчийг зориулж, бодисадвагийн үйлийг дахин дахин хийж, Бурханы билиг оюуныг олж авах (*Нэг Хөлгөн*) явдал юм. Энэ бол маш утга учиртай амьдрал билээ.

Хувилгаан балгасаас гараад явахаар дахиад л шинэ зовлон бэрхшээлтэй тулгарна. Гэвч тэр зовлон нь өмнөх зовлонгоос өөр, бусад хүмүүсийн төлөө гэсэн зовлон болж хувирсан байна. Бусад хүмүүсийн төлөө гэсэн хичээл зүтгэл нь баяр хөөр болж хувирна. Бид энэ үлгэр шиг олон хүмүүстэй хамт аз жаргалын эрэлд яваа билээ. Түүнчлэн Бурхан багш үргэлж бидний дэргэд хамт алхаж байдаг юм шүү.

Чюүо эрдэм шинжилгээний институт



Тайлбарт Нивано Никкёогийн «Цагаан Лянхуа Сударын шинэ тайлбар» болон «Лянхуан Гурамсан Сударын шинэ тайлбар» номыг ашигласан болно.




Гишүүн элсүүлэх нь багшийнхаа ачийг хариулах хамгийн чухал үйл

Энэ сар байгууллагын 80 жилийн ойн тэмдэглэлт сар тохиохын зэрэгцээ Нивано Ничикоо ерөнхийлөгч 80 нас сүүдэр зооглож байгаа билээ. Ерөнхийлөгч цаашид ч гэсэн эрүүл энх байж, гишүүд биднийг удирдан чиглүүлж байгаасай хэмээн хүсэн залбирцгаая.

Ерөнхийлөгч жилийн эхний айлдаваар энэ жилийн өнгө төрхийг “Энгийн байх” хэмээн тодорхойлж түүнийхээ талаар тайлбарласан. Ямар нэгэн зүйлийг хүндрүүлэлгүй, энгийн бөгөөд байгалийн жам ёсны дагуу амьдрах. Мөн байгаль дэлхий, олон зүйлийн ачаар, шүтэн барилдлагын хуулийн дагуу амьдарч байгаагаа санаж явах чухал. Үүнийг “Энгийн байх” гэнэ хэмээн айлдсан.

Түүнчлэн 80 жилийн ойгоор дамжуулан Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан, ахмад багш нарын ачийг хариулах хэрэгтэй хэмээн айлдсан. Тэдний ачийг хариулах хамгийн чухал үйл бол сургаал түгээх юм. Тиймээс гишүүн элсүүлэх үйлийг хичээнгүйлэн хийцгээе.

Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



🌿 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌿

✉️ Коментарите на нашиот е-весник Шан Заи се добродојдени. Ве молиме да ги пракате Вашите коментари на следната. Интернет адреса: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
http://buddhistlearningcenter.org/

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX78269, USA
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai